



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/632

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Жаргалан багийн нутагт 2 дугаар гудамжны 12 тоотод байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай Пүрэвдоржийн Баасанжаргал /ПЮ76031969/-ийн эзэмшлийн 105.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Хүрэлхүүгийн Рэнцэнханд /ИС84121405/-д 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Буянт багийн 1 дүгээр гудамжны 14 тоотод байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Энхтөрийн Гансүх /ПИ93021113/-ийн эзэмшлийн 1000.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Рэнцэнсамбуугийн Хаш-Эрдэнэ /ПЮ87012571/-д мэдээллийн сангийн зургийн дагуу газрын хэмжээг 1093 метр квадрат, хаягыг Ш.Эрэнцэнгийн 2 дугаар гудамжны 226 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Магсаржав багийн ХААН банкны 9 айлын орон сууцны баруун талд байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай Галсаны Хадбаатар /ПЖ82061013/-ын эзэмшлийн 36.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Мандахын Оюун-Эрдэнэ /ПП88030625/-д хаягийг Амарсанаагийн 2 дугаар гудамжны 200 а тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

4. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

5. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ